



**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ**

2026 оны 08 сарын 28 өдөр

Дугаар 112

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай

Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 8.1 дүгээр зүйлийн 9.2, 9.7, 9.8 дахь заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Тусгай зөвшөөрлөө хүчингүй болгох талаар гаргасан хүсэлтийнх нь дагуу “Буян налайх” ХХК-ийн Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт Өргөн нэвтрүүлгийн радио, телевизийн үйлчилгээ эрхлэх 13000007 тоот тусгай зөвшөөрөл, Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт Арилжааны радио, телевизийн үйлчилгээ эрхлэх 12800005 тоот тусгай зөвшөөрөл болон Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутаг дэвсгэрт Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах 22800004 тоот тусгай зөвшөөрлүүдийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

2.Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон шийдвэрийг өөрт нь болон зөвшөөрөл эзэмшигчийн харьяалах татварын албанд мэдэгдэх, холбогдох өөрчлөлтийг мэдээллийн нэгдсэн санд оруулах арга хэмжээ авч ажиллахыг Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газар /З.Эрдэнэчулуун/-т, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус хорооны дарга /Ж.Бат-Эрдэнэ/-д тус тус даалгасугай.

ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

ГИШҮҮД

Б.АНХБААТАР

Ц.ГАНЗОРИГ

Б.ДАГВАСҮМБЭРЭЛ

Ч.ЗОЛБАЯР

С.ТАМИР

А.ҮЙЛСТӨГӨЛДӨР